



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг.

Худалдааны гудамж 6/1, Засгийн газрын V байр.

Утас/Факс: (976-51) 26 75 33, E-mail: foreign@mojha.gov.mn,

<http://www.mojha.gov.mn>

2018.09.24 № 1-1/4597

танай 2018.09.14-ны № 2/4031-Т

ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГА Д.БАТСАЙХАН ТАНАА

Завхан аймгийн Түдэвтэй сумын Засаг даргын 2018 оны "Цагийн хуваарийг шинэчлэн батлах тухай" А/66 дугаар захирамжийг Захиргааны ерөнхий хуулийн дагуу хянан үзэж Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 3995... дугаарт бүртгэснийг үүгээр мэдэгдэж байна.

2018
ХТХ
/



Д.НЯМДОРЖ



Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн санд
2018 оны 09 сарын 24-ны
өдрийн 3995 дугаар бүртгэл.

**ЗАВХАН АЙМГИЙН
ТҮДЭВТЭЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2018 оны 09 сарын 1д өдөр

Дугаар А/66

Ойгон

Цагийн хуваарийг шинэчлэн батлах
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ийн "ж", 29.2, 31 дүгээр зүйлийн 31.1.6 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Суманд үйл ажиллагаа явуулж байгаа худалдаа үйлчилгээний газрын цагийн хуваарийг хавсралт ёсоор баталсугай.

2. Худалдаа үйлчилгээний газруудын ажиглах цагийн хуваарьт хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн хэсгийн дарга Цагдаагийн хошууч Ж.Уламбаяр, Цорго багийн Засаг дарга Г.Түвшинжаргал нарт үүрэг болгосугай.

3. Энэ захирамжийг зөвхөн Улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, Хууль зүйн мэдээлэл сэтгүүлд нийтэлсэний дараа хүчин төгөлдөр мөрдөж ажиллахаар тогтоосугай.

4. Энэ захирамж гарсантай холбогдуулж 2015 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн А/94, 2017 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн А/75 тоот захирамжуудыг хүчингүйд тооцсугай.



ДАРГА *Н. Дамдинбазар* Н.ДАМДИНБАЗАР